



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2019.04.23 № 1599  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичгийг  
хянасан тухай**

Танай байгууллагаас зарласан “Булган аймгийн Хутаг-Өндөр сумын үерийн хамгаалалтын далан барих ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” БУАОНӨГ/201901066 тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “ШИМТ ЭКСПРЕСС” ХХК-иас тус газарт ирүүлсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Холбогдох гомдлыг хянан үзэхэд захиалагч нь тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТООЗ-н 5.2-т “Барилгын зөвлөх инженер-1, Усны барилга байгууламжийн инженер-1 мэргэшсэн зэрэгтэй байх, Геодизийн инженер-1, Автозамын инженер-1, Барилгын материалын инженер-1, Барилгын техникч-1 компанийн үндсэн ажилтан байх ба НД-7, НД-8 маягыг сүүлийн 12 сараар ирүүлэх” гэж тусгасан байна.

“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-д дунд зэргийн төвөгшилтэй усны барилга байгууламжийн ажилд “Барилгын инженер-1, Усны барилга байгууламжийн инженер-1 мэргэшсэн зэрэгтэй байх, Геодизийн инженер-1, Автозамын инженер-1, Барилгын материалын инженер-1, Барилгын техникч-1” гэсэн инженер техникийн ажилтнууд байна гэж заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар” гэж, 16.2-т “Энэ хуулийн 16.1-д заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх шаардлагатай баримт бичиг, тэдгээрт тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт заана” гэсний дагуу захиалагч тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТООЗ-н 5.2-т “Барилгын

0091823

зөвлөх инженер-1, Усны барилга байгууламжийн инженер-1 мэргэшсэн зэрэгтэй байх, Геодизийн инженер-1, Автозамын инженер-1, Барилгын материалын инженер-1, Барилгын техникч-1 компанийн үндсэн ажилтан байх.” гэж заасныг өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймд уг тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг мэдэгдье.

ДАРГА  Б.ЛХАГВА

